НАРАН СУМЫН 11 САРЫН МЭДЭЭ

Боловсролын чиглэлээр:

СУРГАЛТ:

Боловсролын 100 жилийг тохиолдуулан нийт АУБ нар 2021.11.11-ны өдрийн 1-р цагийн хичээлийг “Суралцахын утга учир” сэдвээр зохион байгууллаа.

БМДИ-ээс зохион байгуулсан "Хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх сургалт"ын хүрээнд эхний хичээлийг "ХАМТДАА ХӨГЖИЦГӨӨЕ" онлайн бүлгээр оруулж шалгалт авч ажиллаж байна. Сургуульд суурилсан үнэлгээний арга зүй сургалтанд БДЗАН-ийн ахлагч нар сургалтын менежерийн хамт хамрагдлаа.



Аймгийн насан туршийн боловсролын багш нарын ур чадварын уралдаанд Насан туршийн боловсролын багш Б. Адьяа 3-5-р ангийн сурагчдад холимог бүлгээр "БИДНИЙ БААТРУУД" сэдэвт иргэний боловсролын хичээлийг амжилттай удирдлаа. Хичээлийг бусад сумдын багш нарт туршлага судлах боломжийг бүрдүүлж дижитал технологи ашиглан заалаа.

2021-2022 оны хичээлийн жилд хүүхэд хамгааллын судалгааны үндсэн дээр өндөр эрсдэлт нөхцөлд байгаа 6 суралцагчдад НА-тан анхан шаны кейс нээж, ар гэрээр нь АУБ нартай хамтран гэрийн эргэлийг эргэлт хийж, нөхцөл байдлын үнэлгээг хийж ажилласан.

Нийгмийн ажилтан МУ-ын ГБХЗХГ-аас" Хүүхдийн эрх, эрхийн зөрчил, сургуулийн хүүхэд хамгааллын бодлого- хэрэгжилт" сэдэвт сургалтанд хамрагдсан. МУ-ын ГБХЗХГ, НҮБ-аас зохион байгуулж буй "Хүүхэд хамгааллын сайн дурын сургагч багш бэлтгэх" сургалтанд Дотуур байрны багш, нийгмийн ажилтан нар 2 өдөр хамрагдаж байна. 2021. 10.27-28



11_дүгээр_сарын_20 “ДЭЛХИЙН_ХҮҮХДИЙН_ӨДӨР”буюу "Ye_тэнгийнхний_дээрэлхэлтэнд_өртсөн_хүүхдийг_хэрхэн_таньж_мэдэх, "Хүмүүжлийн_ерэг_аргыг_хэрэглэх_нь" цахим сургалтанд АУБ нар болон дотуур байрны ба, НА-тан нар хамрагдлаа. Мөн 11 сарын 21-ны өдөр “ Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”,” Ye тэнгийн дээрэлхэлт” сургалтанд нийт 10 ангийн эцэг эхийн төлөөлөл оролцлоо





БУСАД:

“Ковид- 19”-н 3-р тунд нийт 22 багш ажилтан хамрагдаад байна. Мөн 7 хоног бүр суралцагчид, багш ажилтны биеийн байдлыг үнэлэх зорилгоор тандалтын багаас гаргасан хуваарийн дагуу гишүүд ээлжлэн оруулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

"Төрийн байгууллагын үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-д албан хаагчдыг бүртгэж баталгаажуулах ажлыг зохион байгуулаа.

Сумын ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний багт 2021 оны ХШҮ-ний ажлаа шалгууллаа. 2021.11.02



Сүхбаатар аймгийн ХШҮ-ний дарга Баасандоржоор ахлуулсан ажлын хэсэг албан газрын дарга эрхлэгч, ХШҮ-ээ хариуцсан мэргэжилтэн нартай уулзаж, 2021 оны үйл ажиллагаанд ХШҮ-ээ хийж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. 2021.11.04

2021.11.01-ны өдөр тогоочийн ажлын байранд сонгон шалгаруулалт хийж Ахлах тогоочоор Б.Болортуяа, туслах тогоочоор Д.Гантуяа, дотуур байрны сурагчдын тогоочоор Э.Эрдэнэцэцэг нарыг авлаа. Мөн няравын ажлын байранд Г.Алтануяа ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсрол

БШУЯ, ЭМЯ-ны хамтран А\292, А\525 тоот түр журмын дагуу коронавирусын цар тахлын үед ажиллах халдвар хамгааллын мөрдөн, хүүхдэд олгох хөгжил төлөвшлийг олгох орчн нөхцлийг сайжруулах зэргээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд

1. Сургалт хүмүүжлийн ажил
2. Эрүүл ахуй халдвар хамгаалал
3. Бүтээлч ажил чиглэлээр тайланг бичлээ.

Бичиг хэргийн ажлыг цаг тухай бүрт нь хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.**Сургалт хүмүүжлийн ажил**

Орчин цагийн боловсрол үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан 4-5 настай хүүхдэд “Эрдэм сурахын ач тус” сэдэвт хичээлийг амжилттай зохион байгуулсан. Энэхүү сэдэвт үйл ажиллагаанд 43 хүүхэд хамрагдсан.

4-5 настай хүүхдүүдийн дунд “Өглөөний дасгал” өглөөлөгийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Өглөөлөгт 3 бүлгийн 42 хүүхэд “Зургийн хичээл”, “Хөгжимт хөдөлгөөн 1,2”,”Алтан тав” зэргийг хийж гүйцэтгэсэн.

Мөн туслах багш нар бүлгийн хүүхдүүдийн дунд “Үлгэрийн орноор аялацгаая” аяны хүрээнд “Тариан түрүү”, “Долоон бор оготно”, “ Тэнэг бяцхан хулгана” үлгэрээр дүрийн тоглолтыг бэлтгэн хүргэсэн. Дүрийн тоглолтонд нийт 42 хүүхэд оролцсон.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Үлгэрч аав ээж” өдөрлөгийг цахимаар зохион байгуулж гэртээ хүүхддээ үлгэр уншиж өгч түүнийхээ бичлэгийг цахимаар илгээж оролцдог. Энэхүү үйл ажиллагаанд 10 эцэг эх хамтран оролцсон. Мөн номын өргөөнд бүлгийн хүүхдийн насанд тохирсон үлгэр өгүүллэгийг уншиж танилцуулсан.

11-н сарын “Танхим болон зайн сургалт”-ын төлөвлөлтийг боловсруулан өдөр тутмын хичээл сургалтыг явуулж байна.

Тусгаарлагдаж байгаа, ажиглалтанд байгаа, эцэг эхийн саналаар цэцэрлэгт

явахгүй байгаа хүүхдийг зайн сургалт руу шилжүүлж, “Би чадна” буюу 10ш гарын авлага, тараах материалыг бэлтгэсэн.

Бүлгийн хүүхдүүдэд “Хэмнэл-хөгжим”-ийн дугуйланг хичээллүүлэх төлөвлөгөөг

боловсруулан алга ташилт, өвдөг цохих, харандаа, халбага, аяга, шагшуур, бөмбөр зэргээр хэмнэл хийж сурсан. Бүлгийн 5 хүүхдэд үлээдэг даралтат хөгжим дээр “Гацуухан дуу”-г зааж байна. Бүлгийн хүүхдийн гарын жижиг булчинг хөгжүүлэх зорилгоор үдээс ашиглан 3-аар

сүлжих сүлжээсийг зааж, хүүхэд бүрийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж байна.

Байгууллагын хүүхэд хамгааллын багийнхан хуралдаж, ажиллах чиглэлээ ярилцсан. Багийн гишүүд хүүхэд хамгаалалтай холбоотой хууль тогтоомжийг бие даан уншиж судаллаа. Мөн эрсдэлд өртсөн 1 хүүхдийн асран хамгаалагчтай уулзаж, тэмдэглэл хөтөлж ажиллав.

2.Эрүүл ахуй халдвар хамгаалал

Өглөө хүүхдийг хүлээн авахдаа болон өдөр унтаж боссоны дараа биеийн халууныг үзэж тэмдэглэл хөтлөж байна.

Өдөр тутмын хоолны үлдэгдлийг тэмдэглэж байна.

7 хоногийн ням гараг бүр хүүхдүүдийн биеийн байдал, аймаг, хотоос хүн ирсэн талаар тандалт хийж ажилладаг.

Өдөр бүр хүүхдийн ус уусан тэмдэглэлийг хөтөлдөг.

Өглөө хүлээн авахдаа бүлгийн хүүхэд бүрт QR код уншуулж, цэцэрлэгт нэвтрүүлэх

ажил явагдаж байна.

7 хоногийн баасан гараг бүр ангидаа их цэвэрлэгээ хийж, хүүхдийн нүүрийн алчуур, хөнжлийн даавуу зэргийг угааж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж хэвшсэн.

Туслах багшийн дэвтрийг зааврын дагуу бөглөж, тэмдэглэл хөтөлдөг.

Өглөө, өдөр, орой хүүхдүүдийн амыг зайлж, гар угаах дарааллын дагуу ариун цэврийг сахиж, дадал хэвшлийг олгосоор байна. Бүлгийн багштай хамтран Улс тунхагласны баярыг тохиолдуулан “Ерөөлч магтаалч хүүхдүүд” өдөрлөгийг бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулах гэж байна. Энэхүү өдөрлөгөөр Төрийн

дууллыг эгшиглүүлэх, дээлийн онцлог, хэв маягтай танилцах, ардын аман зохиолоос унших зэрэг үйл ажиллагаанууд явагдана.

Хүүхдийн хоол хүнсийг гэрээт ААН байгууллагаас авч байгууллагаруу нэвтрүүлэх тухай бүртээ содтой усаар гадна уут сав баглаа боодлыг ариутган халдваргүйжүүлж хүнсний складруу оруулж хэвшээд байна. Өдөр тутмын хүүхдийн хоол хүнсэнд олгосон хүнсээ өдөрлөгийн дагуу олгож өдөрлөгөө түүн хүнсний тайлангаа цаг тухайд нь гарган ажиллаж байна. 10 сарын хүнсний тайлангаа нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн.

ХАБЭА ажилтаны жилийн хийсэн ажлын бичмэл тайлангаа бичиж ЗДТГ-н халамжийн мэргэжилтэнд хүргүүлсэн. 21 заалт бүхий төлөвлөгөөний биелэлтээ гаргасан.

Санхүү хяналт Аудитын албанаас 2019 он, 2020 оны санхүүгийн баримтад шалгалт хийх ажлын хэсэг ирж суманд 6 хоног ажилласан. Тухайн шалгалтад өөрт холбогдолтой ХАБЭА ажилтны хийсэн ажлын тайлан, няравын тайлангуудаа шалгуулж ямарч зөрчилгүй гарсан. Санхүүгийн сахилга бат сайн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн гэсэн дүгнэлт гарсан.

Аймгийн мэргэжлийн хяналтын газраас 2021 оны 11 сарын 19-ны өдрийн 12цагт явуулах яаралтай судалгаа ирсэн. Боловсролын сургалтын байгууллагын ариун цэврийн байгууламжийн эрүүл ахуйн норм, дүрэм стандартын хэрэгжилтийн байдалд хийх тандалт судалгаа, Боловсролын сургалтын байгууллагын ундны усны эх үүсвэр, эрүүл ахуйн норм, дүрэм, стандартын хэрэгжилтийн байдалд хийх тандалт судалгаа ирсэнийг хугацаанд нь гарган явуулсан.

Хүнсний складыг 7 хоног бүр их цэвэрлэгээ хийн хөргөгч хөлдөөгчөө цэвэрлэн өдөр тутмын цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг хийж ажиллаж байна.

Хүнсний складаа өдөр тутамын болон 7 хоногийн цэвэрлэгээг цаг тухай бүрт хийж хэрэгжүүлсэн.

ХАБЭА зардалд зарцуулсан зардлын тайланг хийж сумын ЗДТГ-н хөдөлмөр халамжийн мэрэгжилтэнд хүргүүлсэн.

3.**Бүтээлч ажил**

Сумын ЗДТГ болон соёлын төвөөс хамтран зохион байгуулсан “Угийн бичгээ хөтлөж Удмын сангаа хамгаалья” сэдэвт угийн бичиг хөтлөх уралдаанд байгууллага хамт олноороо оролцож Тэргүүн байр, хувь хүн иргэний төрөлд 2,3-р байруудыг тус тус эзэлсэн.

Улавчны хайрцган дээр тус бүрд нь цэвэр бохир хаягийг шинэчилж өнгө үзэмжийг сайжруулсан.

Багш ажилчдын хувцасны шкафны доод талын гутал хийдэг хэсэгт хөшиг хийж өнгө үзэмжийг сэргээж засварласан.

Байгаль нийгмийн орчин хичээлийг чанартай болгохын тулд “Туршилт танин мэдэхүйн төв”-ийг тохижуулах ажлыг эхлүүлээд байна.

Ангид тав тухтай орчин бүрдүүлэхийн тулд эцэг эхийн дэмжлэгээр 15 м хивсэнцэрийг 450.000 төгрөгөөр авсан.

Эрүүл мэндийн чиглэлээр

Үндсэн үзүүлэлтүүд:

- **Нийт үзлэг-177**
- **Урьдчилан сэргийлэх-112**
- **Артерийн гипертензин эрт илрүүлэг-18**
- **Чихрийн шижин эрт илрүүлэг-18**
- **Жирэмсний хяналтанд хамрагдсан-3**
- **Жинэлсэн хүүхдийн тоо-19**
- **Эмнэлэгт хэвтсэн-63**
- **Холын дуудлага-13**
- **Төвийн дуудлага-59**

Сургалт сурталчилгаа

- **“**Бэрх биш ээлтэй” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулганд “Эмийн зохистой хэрэглээ” талаар сургалт орж 3 төрлийн 60ш зөвлөмж тараан ажилласан.

- Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж 45 төрийн албан хаагчдад нэмэлт 3-р тунгын дархлаажуулалтын талаар мэдээ мэдээлэл хийж 3-р тундаа хамрагдах уриалгыг гаргасан.

• 2021,10,27-28 өдрүүдэд АЭМГ-с “Ковид-19 халдвараас сэргийлэх хариу арга хэмжээ авах, чадавхижуулах” сургалтанд НЭМА, Бага эмч 2 хамрагдсан.

• 2021.11.12-13ны өдрүүдэд ХӨСҮТ-с ковид-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээний багийг чадавхижуулах суралтанд их эмч нэма нар хамрагдсан.

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж

2021.09.04 ковид-19н халдвар дахин бүртгэгдэж нийт тохиолдол 2021.11.20-ны байдлаар 419 тохиолдол бүртгэгдсэн байна.

11-р сард

- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн-17
- Гэрийн эмчилгээ-67 иргэн хамрагдаж эмчлүүлсэн байна.

Эдгэрсэн-296 хүн байна.

- Гэрийн эмчилгээний иргэдийн эмийг эмийн сангаас авч багцлан иргэдэд хүргэн өгч өдөр бүр утсаар холбогдон биеийн байдлыг асууж хяналт хийж АОК,МХГ,ЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.

• 10-15 хүний эмчилгээг сувилагч нар хийж эм тариаг авч цаг хугацаанд нь өгч ажилласан..



• Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын судалгааг гаргаж иргэдтэй холбогдож заавар зөвлөж өгч, ойрын хавьтлыг програмд шивэн оруулж байна.

• Ойрын хавьтлын иргэдийг өдөр бүр шинж тэмдгийн болон хяналтын мэдээг авч бидэнд хүргүүлж түүнийг нэгтгэн АОК,МХГ,АЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.

- Өдөр бүр нөхцөл байдлын мэдээг иргэдэд цахимаар хүргэж байна.
- Ковид-19 халдвараас сэргийлэх 15 төрлийн зөвлөмж болон анхааруулгыг цахимаар иргэдэд хүргэн ажиллаж байна.
- Халдвартай хог хаягдлыг дор бүрэн ангилан ялгаж шатааж байна.
- Ковид-19 халдвараас сэргийлж 3-р тунгын нэмэлт дархлаажуулалтанд иргэдийг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж 928/423/36,9%-тай байна.

Шинэлэг ажил

- Байгууллагынхаа гадна талд ажилчдын ОО хийж байршуулсан. Нүх ухаж, ОО хийх материалаа ажилчид өөрсдөө мөнгө гаргаж материалаа авсан.

- ЗДТГ болон Соёлын төвөөс зохион байгуулсан “ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРЫГ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ” уралдаанд Манай хамт олон “ХОНХОР ШҮҮТИЙН 1,2-Р ХҮН ЧУЛУУ”-ны хашаа болон хаягийг хийж байршуулсан.

Бусад

- Аймгийн Санхүүгийн албанаас албан байгууллагуудын 2019, 2020 оны тушаал шийдвэр, санхүүгийн баримт бичгийг шалгах шалгалт ирж 7 хоног ажилласан.

- АЭМГ-ын дарга, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нар ирж вакцинжуулалтын үйд ажиллаааг эрчимжүүлэх, дэмжэг хяналт хийсэн.

- АЗДТГ-с 2021оны үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийхэн ирж удирдамжийн дагуу бичиг баримтыг шалгуулсан.

- ЭМЯ-с ЭМТ-ийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх зорилгоор эмч ажилчдад 3ш суурин компьтер гардуулан өгсөн.

- 2021.11.18нд АОК,ЭМГ,МХГ-с СОК болон ЭМТ-д ковид-19 халдвараас сэргийлэх тушаал шийдвэрийн хэрэгжилт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг хяналт хийсэн.
- Байгууллагын өрөөний гэрэл болон коридорын гэрлүүдийг солиулж янзалсан.



Соёл урлагийн чиглэлээр

Албан хаагчид мэдлэг боловсролоо дээшлүүлэн ихийг сурч мэдсэн сар боллоо.

Соёлын яамнаас санаачлан зохион байгуулсан “бүтээлч сар” аяны хүрээнд 5 хоног кредит тооцох сертификаттай 5 хоногийн сургалтанд хөгжмийн багш, номын сан, бүртгэл мэдээллийн санч нар хамрагдсан





Үндэсний номын сангаас зохиосон шилдэг номын сан шалгаруулах уралдаанд сум орон нутгаа төлөөлөн материал явуулсан.

Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр,аймгийн номын сангийн төлөвлөгөөний дагуу lib4u программын сургалтанд хамрагдаж ном бүртгэж

Угийн бичгээ хөтөлж удмын сангаа хамгаалья” уралдаанд 15 өрх, 1 байгууллага хамрагдаж үүнээс шалгарсан материалыг аймгийн нийгмийн бодлогын хэлтэст явуулсан.

Түүх соёлын дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах уралдаанд “Эрүүл мэндийн төв” материал ирүүлсэн.

Хяналт шинжилгээ үнэлгээний баг хамт олон ирж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Дотоод аудитын баг хамт олон ирж 7 хоног ажилласан. Үүнд байгууллагын санхүү, номын сан, соёлын төвийн үйл ажиллагааг хянан шалгасан.

1,2,3 дугаар багийн Иргэдийн нийтийн хурал болсон.

Залуу дуучин Отгонбаяр, Амарбат нарын “Тунамал дуулал” тоглолт

Хөдөлмөр нийгмийн халамжийн байцаагч Т.Болорчимэг “бэрх биш ээлтэй” зорилтот бүлгийн иргэдийн уулзалт

Хөдөлмөр эрхлэлт,халамж үйлчилгээний чиглэлээр

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт хамрагдах 1 иргэний материалыг ХХҮГ-т хүргүүлээд байна.

Сүхбаатар аймгийн ХАБЭА-н зөвлөлөөс ирсэн албан бичгийг байгууллагуудад хүргэн судалгааг нэгтгээд байна.

Шинээр -1,ажил зуучлалаар 2 иргэнийг LIMS праграммд бүртгэсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж асаргаа сунгуулах 1 иргэний,шинээр асаргаа тогтоох-1,түлээний хөнгөлөлт авах-1 ахмадын,Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах-1 иргэний асуудлыг хэлэлцсэн.

Асаргааны тэтгэмж ehalamj.mn цахим системд шилжсэнтэй холбогдуулан 64 иргэний мэдээллийг тулган дансжуулсан.

Ахмадын сан байгуулан ажиллах албан бичгийг 5 албан байгууллагуудад хүргүүлээд байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төсөлд 3 бүлгийн төсөл дэмжигдэн 3 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулаад байна. .

Аймгийн засаг даргын А/594 тоот захирамжын дагуу “Бэрх биш ээлтэй”аяныг 10 сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулахаар удирдамж гарган албан байгууллагуудад хүргүүлсэн.

11 дүгээр сарын 02-ны өдөр “Бэрх биш ээлтэй”хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулганыг эрүүл мэндийн төв,соёлын төв,насан туршийн боловсролын багш,нийгмийн даатгалын байцаагч хамтран зохион байгуулсан.

Чуулганаар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл,хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн танилцуулга,хөдөлмөр эрхлэлтээс хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд,ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх,эмийн зохистой хэрэглээ,сайн дурын даатгал,нөхөн тооцох тухай хууль,хуримтлалын талаарх мэдээллийг 35 хүнд хийлээ.Гарын авлагыг тараасан.

Асуулт хариулт,азын сугалаа,урлагын номерын үйл ажиллагаа явагдсан.Хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдэд 176000 төгрөгийн гарын бэлэг,хөгжлийн бэрхшээлтэй 4 өрхөд 200000 төгрөгийн хүнсний тусламжийг олгосон.Азын сугалааг засаг дарга,нийгмийн даатгалын байцаагч,улсын бүртгэгч ивээн тэтгэн 8 азтанг шалгаруулсан.Чуулганаар нийт 438000 төгрөгийг зарцуулсан.

Сард үйлчилгээ үзүүлж байгаа иргэдээ нас,хүйс,боловсрол,үйлчилгээ авсан төрлөөр нь дэлгэрэнгүй бүртгэл хөтлөн ажиллаж байна. Үүний дагуу 11 сарын 22-ны байдлаар 228 хүнд 18 чиглэлээр мэдээлэл өгөн ажилласан байна

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	230	65089802
2	Байнгын асаргаатай ахмад ,хүүхэд ХБИргэдийг асардаг	340	31019890
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд	164	31948790
4	Ахмад настны тухай хуулийн дагуу	135	11207000
5	ХБ хүний эрхийн тухай хуулийн дагуу	133	3298070
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	187	7020223
7	Алдарт эхийн одонтой эхэд	134	17800000
8	Хүүхэд асарсны тэтгэмжинд	856	41700276

Мал эмнэлгийн чиглэлээр

ХШҮ-ний ажлын хэсэг ирж 2021 оны аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын биелэлт зэргийг шалгаж ажилласан. Үүнд: Аймгийн Засаг даргын А/220 тоот захирамжийн биелэлт, тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэргийг шалгуулсан.Мөн аймгийн Мал эмнэлгийн газарт жилийн эцсийн бичмэл тайлан, 4-р улирлын мэдээ зэргийг нэгтгэж гаргаж хүргүүлсэн. Улсын байцаагчийн тоон тайланг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тогтмол явуулдаг.Мал эмнэлгийн цахим гэрчилгээ олголт 11 сарын байдлаар нийт 105 бичигдэж баталгаажуулалт хийгдсэн. Гарсан зөрчил байхгүй. Гадна аймаг сумдаас ирсэн отор нүүдэл шилжилт хөдөлгөөн байхгүй.

Хөдөө аж ахуйн чиглэлээр

Монгол Улсад орчин цагийн худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд “Хэрэглэгчээ дээдэлж соёлтой үйлчилцгээе” аймгийн аварга худалдагч шалгаруулах ур чадварын уралдаан Баруун-Урт хотноо зохион байгуулагдлаа.Уг арга хэмжээнд сумаа төлөөлж “Дэлгэрэх-Ундраа” дэлгүүрийн худалдагч Б.Сумъяа амжилттай сайн оролцоод ирсэн бөгөөд ,Худалдааны байгууллагын 100 жилийн ойн мядалиар шагнууллаа.

Өвлийн идэш арга хэмжээнд оролцох тухай .ХХААХҮ-ийн сайдын А/319 дугаар тушаалаар Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлээд 2021 оны 12 дугаар сарын 20 хүртэл “Өвлийн идэш “-махны өргөтгөсөн худалдааг Улаанбаатар хотноо зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.Дээрх арга хэмжээнд оролцох талаар ААН, иргэдэд зар хүргэж, мөн зөвлөмжийг өгч ажиллалаа.

ХХААХҮ-н сайдын 2021 оны 11-р сарын 09-ны А/314 тоот тушаалын дагуу 2021-2022 оны мал аж ахуйн өвөлжилт,отор нүүдэл,цаг үеийн ажилтай газар дээр нь танилцах бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх,,мал ангилалт бусад цаг үеийн асуудалтай танилцах ажлын хэсэг ирж ажиллалаа.

10-р сарын 27-30-ны хооронд мал ангилалт , ээмэгжүүлэлтийн ажлаар 1,2,3-р багт 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 602 толгой үхэр сүрэгт ээмэгжүүлэлт 52 үхэр ангилалтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Тус ажлын зардалд 30 л 83450 төгрөгний бензин шатахуун зарцуулсан.

Ангилалт бүртгэлжүүлэлт, өвөлжилтийн ажлын дүн мэдээг нэгтгэж аймгийн хөдөө газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан.

11-р сарын 15-нд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн.

11-р сарын 04-нд хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг суманд ажиллаж тогтоол шийдвэрийн биелэлт , албан даалгавар, гэрээний биелэлт болон захирамж тушаалын хэрэгжилттэй танилцаж үнэлгээ өгөн заавар чиглэл өгч ажиллалаа.

Төсөв,төрийн сангийн чиглэлээр

Төсөв санхүүгийн чиглэлээр:

10-р сарын гүйлгээнүүдийг төсвийн хуваарийн дагуу хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг үндсэн

Ба нэмэлт дансаар гаргаж, СА-ы даргаар хянуулж ажилласан.

Нийгмийн даатгалын тайланг хугацаанд нь гаргаж, НД-ын байцаагчаар хянуулж ажиллалаа.

Шилэн дансны мэдээллийг /Сар бүр, тухай бүр, улирал бүр/-ээр илгээж ажиллалаа.

2021 оны 3-р улирлын тайланг хийж, Э-тайланд илгээсэн .

Нэмэлт санхүүжилтийн дансаар усны хөнгөлөлтийн үнэ 1977800 төгрөг орж ирсэнийг

Аймгийн Төрийн санд хүсэлт илгээж, зарцуулах эрхийг авч ажиллалаа

11 сарын санхүүжилт орж ирсэнтэй холбогдуулан гүйлгээ хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Багийн засаг дарга нар болон Хүн ам зүйн мэргэжилтэн, ХАА мэргэжилтэнд сар бүрийн хугацаатай мэдээний талаар танилцуулж, төлөвлөгөө гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Аж ахуй нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн улсын тооллогыг Сумын Засаг даргын А/96 тоот захирамжийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 1-ээс 11дүгээр сарын 15-ны хооронд явагдаж сумын хэмжээний 22 аж ахуй нэгж, 21 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн тоолж хамруулсан.



Багийн Засаг дарга, сумдын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудын сургалтын хөтөлбөрийн дагуу Статистикийн хэлтсийн дарга Т.Эрдэнэбат, хэлтсийн мэргэжилтэн Цэрмаа, хэлтсийн мэргэжилтэн Нандин-Эрдэнэ нар ирж сумын Засаг Даргын орлогч, Тамгын газрын дарга, ХАА-н түшмэл, хүн ам зүйн түшмэл, багийн Засаг дарга нарт 1 өдрийн сургалт явуулсан.

Өрийн мэдээ

Байгууллагын нэр: ЗДТГазар

2021-11-01

№	Зарлдлын нэр	Хөтөлбөр	Зориулалт	ЭЗ-ийн ангилал кодоор	Өмнөх сар	Нэмэгдсэн	Хасагдсан	Тайлант сар	Тайлбар
1	Гэрэл цахилгаан	70106	80101	210301	0		0	0	
2.	Түлш халаалт	70106	80101	210302	2354121.70		1800000	544121.70	
3.	Шуудан холбоо интернетийн төлбөр	70106	80101	210403.		126000		126000	
	Нийт дүн					670121.70		670121.70	

Мөн 11-р сарын 01-нээс 15-ны хооронд улс орон даяар ААНэгжийн улсын тооллого болж байгууллагаа хамруулллаа.

11-р сарын 8-наас 15-ны хооронд Аймгийн Санхүү Аудитын газраас 2019 – 2020 оны санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийсэн.

ИТХурал Соёлын төв 2 байгууллагын тухайн сарын мөнгөн гүйлгээг 20-ноос 30ны хооронд хийж гүйцэтгэсэн. Мөн сар бүр гаргадаг төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нийгмийн даатгалын тайлан, шилэн дансны мэдээлэл зэргийг дараа сарын 3-наас 8-ны хооронд хугацаанд нь оруулсан. Хоцорсон мэдээ байхгүй.

10-р сарын 30-ны мэдээгээр:

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	төлөвлөгөө	гйүцэтгэл
1	ИТХурал	64261.1	46.5	39.3 сая 84,5%
2	Соёлын төв	82968.3	58.6	48,1 81,9%

Сүхбаатар аймгийн Санхүү Аудитын албанаас 2019,2020 оны санхүүгийн баримтанд дотоод аудит хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй. Ковид 19 цар тахлын хүрээнд төсвийн хэмнэлтийг мөрдөж ажиллах Засгийн газрын тогтоолыг баримтлаж ажиллаж байна.

Байгаль орчины чиглэлээр.

Дарьганга сумын БЦГазрын хамгаалалтын захиргаанаас зохион байгуулсан Тусгай хамгаалалттай газар нутаг дахь Орчны бүсийн сумдын ерөнхий боловсролын сургуулийн “ШИЛДЭГ ЭКО КЛУБ” шалгаруулах зөвлөгөөнд НАРАНБУЛАГ эко клубын сурагчид амжилттай оролцож 2021 оны үйл ажиллагаагаараа 2-р байр эзэллээ.

ЗДТГ болон сумын Соёлын төвтэй хамтран албан байгууллагын дунд “Түүх соёлын дурсгалт газрыг хамгаалж тохижуулах” уралдааныг зарласан бөгөөд уг уралдаанд сумын ЭМТ-ийн хамт олон оролцож сумын 2-р багийн нутагт орших “Хонхор шүүтийн 1, 2-р хүн чулуу”-г хашаажуулж хаяг хийж байршуулсан.

Сумын 3-р багийн засаг дарга Б.Цолмонтой хамтран сумын төвийн золбин нохой устгалын ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Одоогийн байдлаар 11 нохойг устгаад байна.

“Сүхбаатар аймгийн усны сан бүхий газрын хамгаалалалтыг бүс тогтоох ажлын хэсгийн уулзалт, хэлэлцүүлэг”-т ИТХ-ын дарга Ө.Гантулга-н хамтаар оролцсон.

Сумын эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан “Ковид-19” тунгийн өнөөгийн нөхцөл байдал, 3-р тунгийн хамрагдалтын тухай сургалтанд ажилчдын хамт хамрагдсан.

Сумын 1-р багийн нутагт хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “ИОН ЭНЕрЖИ” ХХК-ын үйл ажиллагаа явуулсан талбайг сумын засаг дарга Л.ОЧ, хөдөө аж ахуйн мэргэжилтэн Б.Балжинням нарын хамт очиж хүлээн авлаа. Уг компани нь 1-р багийн нутагт нийт 80 гаруй цэгээс дээж авсан бөгөөд нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хийж хүлээлгэж өгсөн.

Өвлийн бэлтгэл ажлыг хангах, малчдын өвсний нөөц тэжээлийг бэлтгэх зорилгоор Дарьганга сумын иргэн Н.Батхүрэлтэй гэрээ байгуулан өвсний фонтонд нийт 4000 ширхэг өвсийг нөөцөлж багийн засаг дарга, хаа-н мэргэжилтэн нартай хураасан.

Сүхбаатар аймгийн БОАЖГ-н сэтгэл ханамжийн судалгааг 10 иргэнээр бөглүүлсэн.

Улсын бүртгэлийн чиглэлээр

Иргэний бүртгэлийн үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу тасралтгүй хүргэн ажиллаж байна.

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл Үүнд:

-Төрсний бүртгэл-2

-Гэрлэлтийн бүртгэл -1

-Гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл-1

-Нас барсан-1

Иргэний цахим үнэмлэх олголт

-Иргэний үнэмлэх захиалга ИУБ31-5 иргэн

-Иргэний үнэмлэх олголтын бүртгэл-9 иргэн

-Иргэний үнэмлэхний лавлагаа албан хэрэгцээнд -13

-Гэрлэлт бүртгэлгүй лавлагаа албан хэрэгцээнд -2

-Гэрлэлт бүртгэлийн лавлагаа иргэнд-1

-Гэрлэсний лавлагаа албан хэрэгцээнд -3

-Төрсний лавлагаа албан хэрэгцээнд – 1

-Төрсний бүртгэлийн лавлагаа иргэнд-2

Иргэний шилжилт хөдөлгөөн

-Аймаг нийслэлээс шилжиж ирсэн-1

-Сум хооронд шилжиж ирсэн насанд хүрсэн -2, хүүхэд-2

гэх мэт иргэний бүртгэлийг холбогдох бичиг баримтыг хүлээн авч хүсэлтийн дагуу

шийдвэрлэж ИУБ хаадар маягтуудыг Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэст сар бүрийн 25-нд үнэт цаас ,үйл ажиллагааны тайлан мэдээг тогтмол цаг хугацаанд хүргүүлж байна.

Мөн аймаг, хот, сум, дүүрэг, баг хооронд, иргэний үнэмлэх олголт үрчлэлт ,гэрлэлт, шинэ төрсөн, зэрэг журналуудыг хөтлөж байна.

ХБИргэний чуулган зохион байгуулж тухайн иргэдийн дунд сугалаа зохион байгуулж 1 иргэнд 10,000 төгрөгийн сугалаанд дэмжлэг үзүүлсэн.

Сумын иргэний үнэмлэхний хугацаа дууссан хаяж гээгдүүлсэн зорилтот бүлгийн иргэдийн судалгаа УБХ хүргүүлсэн.

УБХ-ийн 2021 оны 11 сарын 23-ны онлайн хуралд хамрагдсан.

Бусад:Ойрын хавьталын тандалтын мэдээг 2021.11.04,08,14,20,24-нд мэдээг хүргэж өгсөн.

Татварын чиглэлээр.

Татварын үйлчилгээг ард иргэдэд хуулийн дагуу тасралтгүй хүргэж ажиллаж байна.

Татвар хураалттай холбоотой дараах үйл ажиллагааг голлон явууллаа.

Үүнд:

- Малын хөлийн албан татварт энэ сард 9,086,700₮-ний орлого ЗДТГ-ын дансанд төвлөрүүлсэн.Татвар хураалт 49%-тай явагдаж байна.
- Цагдаатай хамтарч галт зэвсэгтэй иргэдийн дунд судалгаа явуулсан
- Галт зэвсэгийн албан татварт 630,000₮-ийн орлогыг ЗДТГ-ын дансанд төвлөрүүлж,татвар хураалт 97%-тай явагдаж байна.
- Улсын тэмдэгтийн хураамж 400,000₮-ийн орлого ЗДТГ-ын дансанд төвлөрүүлсэн.
- Тасгаар 8 иргэнд Е-баримт нээх сэргээх,нууц үгээ хэрхэн сэргээх талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.
- Авто АБТ-18,400₮
- АТБӨЯХАТ-115,789₮
- Газрын татварт 1,987₮
- Зам ашигласан төлбөрт-15,000₮ гэх мэт татвартай холбоотой үйл ажиллагаа явуулсан.

Тайлан нэгтгэсэн:

Хууль эрхзүй дотоод хэрэг хариуцсан мэргэжилтэн Э.Сувд-Эрдэнэ

Утас: 96026607